



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг)¹

НОТЛОХ БАРИМТЫГ ЦУГЛУУЛЖ, БЭХЖҮҮЛЭХЭД ХУУЛЬ ЁСНЫ БАЙХ ШАЛГУУРЫГ ХАНГААГҮЙН УЛМААС ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЭРЭГСЭХГҮЙ БОЛГОВ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: ХШТ/2026/08

Шүүхийн шийдвэрийн огноо: 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч нь тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр 1 жилийн хугацаагаар хасуулсан байхдаа буюу 2025 оны 05 дугаар сарын 19 ний өдөр *** аймгийн *** сумын *** багийн нутаг дэвсгэрт согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн байдалтайгаар улсын дугааргүй “Мустанг-5” маркийн механикжсан тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцсон гэмт хэрэгт холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- 1. Анхан шатны шүүх:** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д зааснаар аймгийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг² зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн шүүгдэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж шийдвэрлэсэн.
- 2. Давж заалдах шатны шүүх:** Анхан шатны шүүхийн цагаатгах тогтоолыг хэвээр үлдээн шийдвэрлэжээ.
- 3. Прокурор хяналтын шатны шүүхэд гаргасан эсэргүүцэлдээ:** “...Хэрэгт цугларсан нотлох баримтуудаас үзвэл шүүгдэгч нь согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн эсэхээ шалгуулахаас зайлсхийсэн, түүнээс биологийн дээж буюу цус авч, шинжлүүлсэн байдаг...Энэ нь “шүүгдэгч амьсгал дахь спиртийн агууламжаа

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/3813?daterange=2026-01-01%20-%202026-04-20&id=3&court_cat=2&bb=1

² Эрүүгийн хууль (2015)-ийн 27.10 дугаар зүйлийн 5 дахь хэсэг “тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан хүн согтуурсан, мансуурсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл согтуурсан, мансуурсан эсэхийг зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол тээврийн хэрэгслийг жолоодох эрхийг нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”



шалгуулахаас зайлсхийсэн этгээд” гэсэн төлөвт шилжинэ. Мөрдөгч нь хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.10 дугаар зүйлд заасныг зөрчөөгүй, шүүгдэгч нь согтуурлаа шалгуулахаас татгалзаж, өөрийн хүсэлтээр биологийн дээж буюу цус өгөхөөр болсон талаар тэмдэглэл үйлдэж, ажиллагаа явуулсан нь хуульд нийцсэн. Энэ хэрэгт цугларсан бичгийн нотлох баримтуудыг хууль бус аргаар цуглуулж бэхжүүлсэн, хэн нэгний эрхийг хязгаарласан гэж үзэх үндэслэл тогтоогдоогүй тул анхан шатны шүүхийн цагаатгах тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэх үндэслэлтэй байна.” гэжээ.

4. **Хяналтын шатны шүүх:** Анхан болон давж заалдах шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтууд, тэдгээрийн хууль ёсны байдалд үндэслэл бүхий дүгнэлт хийж, шүүгдэгчийг цагаатгасан нь хуульд нийцсэн байна гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.(20).
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд “нотлох баримт”³ гэдэг нь зөвхөн мэдээлэл агуулсан баримт бичиг бус, харин хуульд заасан арга хэрэгслээр цуглуулж, бэхжүүлсэн, эх сурвалж нь тодорхой, шалгаж тогтоогдсон мэдээлэл байх учиртай. (21).
6. Шүүхийн шийдвэрийн үндэслэл болж буй нотлох баримт нь хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хууль ёсны байх гэсэн шалгуурыг зэрэг хангасан байхыг нотолгооны онолд шаарддаг. (23).
7. **Хэрэв нотлох баримт нь хууль ёсны байх шалгуурыг хангаагүй бол түүний агуулга хэдийгээр хэргийн бодит байдлыг илэрхийлж байсан ч шүүх түүнийг нотлох баримтаар үнэлэх боломжгүй юм.** (25).
8. Замын цагдаагийн зохицуулагчийн явуулсан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад “шүүгдэгч нь согтуурлаа шалгуулахаас татгалзаж, өөрийн хүсэлтээр биологийн дээж /цус/ өгөхөөр болсон тул дээж авах шаардлагатай”-г 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн “Жолоочийн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн эсэхийг шалгасан тэмдэглэл”-д тусгагдсан байна. (27).
9. Биологийн дээж авах ажиллагаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтын эх сурвалжийг бүрдүүлэхэд чиглэсэн, хуульд нарийвчлан журамласан онцгой ажиллагаа бөгөөд **уг ажиллагааг хуульд заасан журмыг зөрчиж явуулсан тохиолдолд түүнд үндэслэн гаргасан шинжээчийн дүгнэлт нотлох баримтын ач холбогдолгүй болох эрх зүйн үр дагавар үүсдэг болно.** (28).
10. Дээрх үйл баримтаас үзэхэд, шүүгдэгч согтуурлаа шалгуулахаас татгалзаж, өөрийн хүсэлтээр биологийн дээж өгөхөөр болсон нөхцөл байдалд цагдаагийн байгууллагын ажилтан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн захирамжилсан /императив/ хэм хэмжээг зөрчсөн байна.(29).
11. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Мөрдөгч ...хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авахыг... **прокурорын зөвшөөрлөөр явуулна**” гэж, мөн хуулийн 22.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт уг ажиллагааг явуулах саналыг мөрдөгч прокурорт гаргахаар тус тус хуульчилсан. (30).

³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий, энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.”



12. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт зааснаар мөрдөгч хойшлуулшгүй тохиолдолд хүний биеэс шинжилгээнд зориулж биологийн дээж авах мөрдөн шалгах ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүй явуулж болох эрхтэй хэдий ч прокурорт даруй мэдэгдэж, ажиллагаа дууссанаас хойш 24 цагийн дотор тухайн ажиллагааг хүчинтэйд тооцуулахаар зөвшөөрөлгүй явуулах болсон үндэслэлийг нотлох баримт, тайлбарыг прокурорт бичгээр хүргүүлэхээр хуульчилжээ. (33).
13. Прокурор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар мөрдөгчийн баримт, тайлбарыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор мөрдөн шалгах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг шийдвэрлэдэг. (34).
14. Мөрдөн шалгах ажиллагааны явцад прокурорын зөвшөөрөлгүйгээр биологийн дээжийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 7⁴, 16.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар нотлох баримтаар тооцохгүй байх үндэслэлд хамаарах тул хууль бус аргаар бэхжүүлсэн дээжид хийсэн шинжээчийн дүгнэлт нотлох чадвараа алдаж, шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй. (35).
15. Иймд шүүгдэгчийг цагаатгасан анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, прокурорын бичсэн эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэв. (36).

---o0o---

⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Энэ хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй.”